

2021 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022.01.10

№	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
НЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх	Байгууллагын алсын хараа болон эрхэм зорилго үйл ажиллагааны чиглэл болон тасаг нэгжүүдийн мэдээлэл эмч нарын мэдээллийг цахим хуудсанд баайрлуулсан. УХТЭ-ийн цахим хуудас болох http://ssch.gov.mn веб сайтын ил тод байдал цэс нь • Үйл ажиллагааны ил тод байдал • Төсөв санхүүгийн ил тод байдал • Худалдан авах ажиллагааны ил тод байдал • Хүний нөөцийн ил тод байдал • Эмнэлгийн мэрэгжилтэний ёс зүйн салбар хороо • Авлигын эсрэг үйл ажиллагаа гэсэн дэд цэснээс бүрдэх бөгөөд. Эмнэлгийн даргын тушаалууд, үйл ажиллагааны тайлан төлөвлгөө, төсөв санхүүгийн ил тод байдлын мэдээллүүд, нээлттэй ажлын байрны зар, шаардлагатай утасны жагсаалтуудыг байрлуулсан тогтмол шинэчилдэг. Санхүү төсвийн тухай хуулийн дагуу https://shilendans.gov.mn/ сайтын УХТЭ-ийн хуудсанд мэдээлүүдийг тухай бүрд нь оруулдаг.	100%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр,өөрийн нэ=№-р, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартай ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх	Байгууллагын http://ssch.gov.mn цахим хуудсаар өргөлт гомдол болон санал хүсэлтийн мэдээллийг хүлээн авдаг. Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар, дотоод хяналтын албаны 70150205 тоот утасны дугаарыг ил байршуулан санал хүсэлт, өргөдөл гомдлыг утасаар болон биеэр бичгээр аван тогтмол шийдвэрлэн ажиллаж байна. • ЭМТҮЧБА нь иргэд, үйлчлүүлэгчдийн санал гомдол, талархлыг ажлын өдрүүдэд 08:20-16:20 цагийн хооронд хүлээн авч, асуудлыг шийдвэрлэн ажилладаг	100%
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа	Эмнэлгийн веб хуудсанд амбулаторын ажиллах цагийн хуваарь,	

	ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Амбулаторит үзлэгийн цагийг цахимаар захиалах, лавлах утасны дугаар, эмнэлэгт ирэхдээ авч ирэх шаардлагатай бичиг баримтын жагсаалт болон үйлчлүүлэгчид өгөх зөвлөгөө болон төлбөрт тусламж үйлчилгээ, даатгалын мэдээллүүдийг сар бүр шинэчилэн ажиллаж байна	
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	2021 оны 6 дугаар сараас Эмнэлгийн цахим хуудасны баазын алдаа гарсны улмаас 10 дугаар сар хүртэл ажиллаагүй улмаас тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулах асуудал хийгдээгүй болно. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг ажилчдын хувийн цахим хаяг, эмнэлгийн телеграмм болон facebook хуудсаар тасралтгүй хүргэсэн.	80%
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	2021 оны 6 дугаар сараас Эмнэлгийн цахим хуудасны баазын алдаа гарсны улмаас 10 дугаар сар хүртэл ажиллаагүй тул байгууллагын дотоод журмыг шинэчлэх ажлын хүрээнд байгууллагын ажилчдын хувийн цахим хаягруу санал болон шийдвэрийн төслийг явуулж санал авч, түүнийгээ удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан.	80%
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Олон улсын JCI стандартын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтуудын хүрээнд нийт 20 гаруй журам боловсруулан эмнэлгийн ерөнхий захирлаар батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Журмуудын чиглүүлэх сургалтуудыг хөтөлбөрийн дагуу эмнэлгийн ажилтнуудад тасралтгүй байдлаар зохион байгуулж байна. Холбогдох журмуудын мөрдөлтөд тасгийн эрхлэгч нар, ЭМТҮЧАБА, ЭЭДЗ нар хяналт тавин ажиллаж байна.	100%

		IPSG 1 буюу “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах” нэгдүгээр зорилтын хүрээнд: “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах тухай” УХТЭ-БМ-06 ТҮЖ 19:2021-1 журмыг мөрдөн ажиллаж байна. Журамд заасны дагуу эмнэлгийн хэмжээнд үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахад дараах тогтсон 2 аргыг ашиглаж байна. IPSG 2 “Үр дүнтэй харилцаа бий болгох” хоёрдугаар зорилтын хүрээнд” нийт 6 журмыг эмнэлгийн захирлаар батлуулан мөрдөж ажиллаж байна. 3 журмыг шинэчлэн боловсруулж шинээр 3 журам боловсруулсан. Үүнд: 1.“Аман заавар өгөх тухай” УХТЭ-БМ-06 ТҮЖ 22:2021-1 2. “Үйлчлүүлэгчийг тасагт хүлээн авах, гаргах тухай журам” УХТЭ-БМ-06 ТҮЖ 21:2021-1 3. “Шинжилгээний үр дүн сэрэмжлүүлэх/аюултай хязгаарт хүрсэн тохиолдолд авах арга хэмжээний журам” УХТЭ-БМ-17 ТҮЖ 29:2021-3 4. “Яаралтай шинжилгээ хийх, мэдээлэх журам” УХТЭ-БМ-17 ТҮЖ 21:2021-2 5. “Радиологи шинжилгээний аюултай хариуг мэдээлэх журам” УХТЭ-БМ-06 ТҮЖ 23:2021-1 6.”Өвчтөн шилжүүлэх тухай” УХТЭ-БМ-02 ТҮЖ 12:2019-2 “Хагалгааны дуран түүний дагалдах хэрэгслийг угаах, халдваргүйтгэх, ариутгах тухай журам УХТЭ-БМ-09 ТҮЖ-6:2021-2 Цэвэрлэгээ хийх тухай журам УХТЭ-БМ-28 ТҮЖ-1:2021-2	
--	--	---	--

		Эөөлөн эдлэл, цагаан хэрэглэл, хувцас угаах үйл ажиллагааны журам УХТЭ-БМ-09 ТҮЖ-8-2021:2 Эмгэг хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх журам УХТЭ-БМ-09 ТҮЖ-9:2021-3 Хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх тухай УХТЭ-БМ-09 ТҮЖ-10-2021:1 IPSG 6 “Унах бэртэх эрсдэлээс сэргийлэх” зургадугаар зорилтын хүрээнд: Эмнэлгийн захирлын 2021 оны 06 дугаар сарын 02-ний өлрийн А/79 дугаар тушаалаар “Унах эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх журам” УХТЭ-БМ-06 ТҮЖ 1:2021-2 -ыг шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	Байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг байгууллагын цахим хуудасны Нүүр хуудас http://ssch.gov.mn /-д байршуулсан.	100%
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Зөвшөөрөл олгодоггүй	100%
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын	Тус эмнэлэгт БНСУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй КОFИH сангийн санхүүжилттэй Канбуг самсунг эмнэлэгтэй хамтарсан тус эмнэлгийн үндэсний оношилгоо эмчилгээний төвийн консалтинг буюу сургалт, зөвөлгөөний төслийг 2021-2022 онд хэрэгжүүлж ажиллахад	100%

	талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх	тус эмнэлгийн фэйсбүүк болон телеграмаар уулзалт, сургалт, хамтарсан семинар, уулзалтуудыг тухай бүрт мэдээллийг цахим хуудсанд байршуулж мэдэгдэж байсан.	
Хэсгийн дундаж хувь 84,4%			
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Эмнэлгийн сул орон тооны зарыг өөрийн цахим хуудас болон ажлын байрны зарын сайтуудад нээлттэйгээр байрлуулдаг. https://info.shilendans.gov.mn/login “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан. Эмнэлгийн ЦАХИМ хуудасны http://ssch.gov.mn/ “АЖЛЫН БАЙРНЫ ЗАР” буланд 20 удаа нийт 20 ажлын байрны зар, эмнэлгийн Facebook page-д 42 удаа 40 ажлын байрны зарыг байршуулсан - Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд 2 ажлын байрны захиалга өгсөн. - Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хөдөлмөрийн яармаг-2021”-т цахим арга хэмжээнд 11 ажлын байрны 40 сул ажлын байрны зар, мэдээлэл хүргэн оролцсон.	100%
2.	Албан хаагчийн ёс зүй дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Иргэд болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас байгууллагын хүний нөөцийн удирдлагатай холбоотой гарсан гомдол байхгүй болно. Иргэд, эмнэлгийн ажилтнаас байгууллагын мэдээллийн ил тод байдалтай холбоотой гарсан гомдол байхгүй.	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг цахим хуудсанд байршуулав.	100%
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	https://info.shilendans.gov.mn/login “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан. - Шинээр ажилд орсон нийт 107 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.	100%

		• Эмнэлгийн ЦАХИМ хуудасны http://ssch.gov.mn/ “АЖЛЫН БАЙРНЫ ЗАР” буланд 20 удаа нийт 20 ажлын байрны зар, эмнэлгийн Facebook page-д 42 удаа 40 ажлын байрны зарыг байршуулсан • Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд 2 ажлын байрны захиалга өгсөн. • Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хөдөлмөрийн яармаг-2021”-т цахим арга хэмжээнд 11 ажлын байрны 40 сул ажлын байрны зар, мэдээлэл хүргэн оролцсон.	
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	• Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 51.1, 52, 53, 72.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1,2,3,4,5 дугаар хавсралт, 2019 оны 05, 25, 276, 472 дугаар тогтоол, 2020 оны 151 дүгээр тогтоол, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын хавсралт, Эрүүл мэндийн салбарын 2020-2021 оны хамтын (тариф)-ын хэлэлцээрийн 3,4 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 69 дүгээр тушаалын 1,4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар Албан даалгаврын 1.6 дахь заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/06, А/25, А/29, А/39, А/59, А/75, А/101 дугаар тушаалаар баталсан Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны албан тушаалын зэрэглэл, шатлал, үндсэн цалингийн сүлжээ, Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл, ажилтны албан тушаалын жагсаалт, Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд сар бүр олгох ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдэл, урамшууллыг цаг хугацаанд нь тооцон олгосон. • АУ-ны, техникийн ухааны доктор 12, Зөвлөх эмч 10, тэргүүлэх зэргийн эмч, эм зүйч-35, ахлах зэргийн эмч, эм зүйч-28, зөвлөх сувилагч-1, тэргүүлэх зэргийн сувилагч, тусгай мэргэжилтэн-40, ахлах зэргийн сувилагч, тусгай мэргэжилт-32, бусад мэргэжилтэн 6 ажилласан байна. Эмнэлгийн эрдмийн болон мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтнүүдийн 52,6 хувь болсон ба тогтоолын дагуу	100%

	эмнэлгийн эмч, мэргэжилтэн, ажилтанд 169,607,413 төгрөгийн нэмэгдэл олгосон. • Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 1 ажилтанд 40%-иар 5 ажилтанд 15%-иар, 14 ажилтанд 10%-иар тооцон нийт 36,821,562 төгрөг тооцон олгосон. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын дагуу ажлын хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 148,950,321 төгрөгийг 242 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын дагуу хоол, унааны нэмэгдэл 579,989,000 төгрөгийг 754 ажилтанд олгосон. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 52, 53 дугаар зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1,161,594,953 төгрөгийг эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Дуудагдан ажилласны хөлс болох 71,644,942 төгрөг эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эрүүл мэндийн салбарын 2020-2021 оны хамтын (тариф)-ын хэлэлцээрийн 3,4 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 69 дүгээр тушаалын 1,4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар Албан даалгаврын 1.6 дахь заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 163,897 цагийн 163,897,000 төгрөг олгогдсон. • 2021 оны 01 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажилласан нийт 623 (давхардсан тоогоор)	
--	---	--

		эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын 89,302 цагийн илүү цагийн хөлс 1,277,925,342 төгрөгийг тооцон олгосон. • Эмнэлгийн ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/85 дугаар тушаалаар нийт эмнэлгийн ажилчдад 2,500 төгрөгийн үнэтэй 10 ширхэг иж бүрдэл хоол, 1,500 төгрөгийн үнэтэй 8 ширхэг иж бүрдэл хоолны жор, орц, цэсийг шинээр батлуулан өдөр бүр иж бүрдэл хоолоор үйлчилж эхэлсэн. Тус иж бүрдэл хоол нь 730-920 ккал-ийн илчлэгтэй бөгөөд энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар батлагдсан “Хоногийн хоол хүнсээр авбал зохих ичлэг, үндсэн шимт бодисын зөвлөмж, хэмжээ, шаардлага”-ыг хангаж байгаа юм. • Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/111 дугаар тушаалаар Эмнэлэг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаа үед шүүлтүүр хэсэг, ажиглан тусгаарлах байрны эмнэлгийн мэргэжилтэн, онцгой тохиолдолд ажиллах гамшгийн штаб, хариуцлагатай жижүүр нарт өглөөний цай, оройн хоолоор хангахыг “Шөнийн ээлжийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг өглөөний цай болон оройн хоолоор хангах тухай” тушаалыг шинэчлэн баталсан. • Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/121 дугаар тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудыг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн ажилчдын дархлааг дэмжих зорилгоор халуун аарцаар 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл олгохоор шийдвэрлэсэн. • Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед эрсдэлт бүлгийн судалгаа гаргаж, нийт давхардсан тоогоор 45 жирэмсэн эмнэлгийн ажилтанд тэтгэмжтэй чөлөө олгосон. (Эмнэлгийн ерөнхий захирлын А/19, А/60, Б/117 дугаар тушаал)	
--	--	---	--

	• Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл нь нийт 94,870,444 (2516 нийт хоногийн) эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтанд Ажил олгогчоос 50,974,240 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 43,896,206 төгрөгийн тэтгэмж олгосон. • Коронавируст халдвар /КОВИД-19/-ын халдвараар өвдсөн нийт 209 ажилтанд өвдсөн хугацааны үндсэн цалин буюу 64,798,642 төгрөгийн цалин хөлсийг олгосон • Ахмад настны нийгмийн хамгааллын тэтгэмжийн тухай хуулийн 8.4 дэх заалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 09 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтын дагуу Ахмадын өдрөөр байгууллагын 227 ахмадуудад хүндэтгэл үзүүлж нийт 6,160,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2021 оны А/114 дүгээр тушаал) • 2021 онд эмнэлгийн ажилтны хэрэглээний зээлийн баталгааг баталгаажуулах зорилгоор ХАС банктай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 295 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 1 тэрбум 9 сая төгрөгийн цалингийн зээл олгоход байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлсэн • Монгол Улсын Төсвийн хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу Санхүү бүртгэлийн болон Эдийн засаг, төлөвлөлтийн албаны нийт 15 ажилтанд 20,636,233 төгрөгийн урамшуулал олгосон (Эмнэлгийн ерөнхий захирлын 2021 оны А/115, А/120 дугаар тушаал). • “Тасгийн ажлын гүйцэтгэлийн биелэлт дүгнэх ажлын хэсэг” томилон тасгуудын жилийн үйл ажиллагааны биелэлт, ажлын гүйцэтгэлийн шалгуур” Эмнэлгийн даргын 2016 оны 238 дугаар тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу Ажлын хэсэг томилон ил тодоор дүгнэж, 2021 оны 12 дугаар сарын 15,17-ны өдрийн Удирдлагын зөвлөлийн хурал дээр үр дүнг хэлэлцэн “Шилдэг	
--	---	--

	тасаг"-ууд, "Эмнэлгийн шилдэг эмч,сувилагч, ажилтан" шалгаруулан нийт 14,200,000 төгрөгөөр шагнаж урамшуулсан (Эмнэлгийн ерөнхий захирлын 2021 оны 12 дугаар сарын А/146 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралт). • Эрүүл мэндийн салбарын шагналаар: "Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан" тэмдэгээр 45, ЭМ-ийн яамны "Жуух бичиг"-ээр 59 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан шагнагдсан ба шагналд нийт 6,270,000 төгрөг зарцуулсан. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2021 оны А/70, А/101 дүгээр тушаал). • Дотрын анагаах судлал, Дүрс оношилгоо судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал чиглэлээр үндсэн мэргэшлээр суралцаж байгаа резидент эмч нарт лекц болон дадлага удирдсан 42 эмч-багшид 33,427,200 төгрөгийг хичээл заасан цагийн хөлс олгосон (Эмнэлгийн захирлын 2021 оны А/144 дүгээр тушаал). • Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2021 оны I улиралд 522 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 179,023,016 төгрөг, II улиралд 522 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 170,698,661 төгрөг, III улиралд 491 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 140,985,245 төгрөг, IV улиралд 458 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 173,914,450 төгрөг, олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2021 оны А/58, А/88, А/119, А/145 дугаар тушаал)	
Хэсгийн дундаж хувь 100%		
Хэрэгжилтийн дундаж хувь 92,2%		